

## МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБООНЫ ТАМИРЧДЫН ЧАНСАА, ШИГШЭЭ БАГИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Монголын загасчлалын спортын холбоо (цаашид “МЗСХ” гэх) -ноос загасчлалын спортын төрөл тус бүрээр тамирчдын чансаа (ранк) хөтлөх, шигшээ багийг бүрдүүлэх, түүний бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулна.

### Хоёр. Тамирчдын чансаа, түүнийг хөтлөх

- 2.1. МЗСХ нь загасчлалын спортын төрөл тус бүр дээр УАШТ-ний үр дүнгийн дагуу тамирчдын чансааг хөтлөн, жил бүр шинэчилнэ.
- 2.2. УАШТ-ээс бусад ОУ-ын дүрмийн дагуу явагдсан МЗСХ-ны хуваарьт албан ёсоор орсон тэмцээн тус бүрийн үр дүнгийн дагуу тамирчдын чансааг тусад нь гаргаж болно.
- 2.3. Тамирчдын чансааг ОУ-ын холбооны ранк гаргах аргачлалын дагуу 5 жилээр (сүүлийн 6 жилийн үр дүнг оролцуулан) гаргана.
- 2.4. Загасчлалын спортын тухайн төрлийн болон тухайн жилийн шилдэг баг, клубыг тодорхойлох зорилгоор багийн чансааг гаргаж болно.
- 2.5. Баг, тамирчдын чансааг гаргах ажлыг МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга зохион байгуулж, баталгаажуулна.
- 2.6. Баг, тамирчдын хөтлөгдсөн чансааг МЗСХ-ны гишүүн холбоо, клубууд, тамирчид, олон нийтэд нээлттэй мэдээнэ.

### Гурав. Шигшээ багийг бүрдүүлэх

- 3.1. Шигшээ багийг бүрдүүлэх үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг удиртгал болгож шударга бус өрсөлдөөн, ашиг сонирхлын зөрчил, авилга хахуулиас ангид байх зарчмыг баримтална.
- 3.2. Шигшээ багт багтах тамирчдад дараах шаардлага тавигдана. Үүнд:
  - 3.2.1. Монгол улсын иргэн байх
  - 3.2.2. МЗСХ-ны гишүүн аль нэг холбоо, клубт харьяалагддаг байх
  - 3.2.3. Өндөр амжилт гаргах магадлалтай, ур чадвартай, бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд хэвийн байх
  - 3.2.4. Тухайн төрлийн УАШТ, бусад ОУ-ын дүрмийн дагуу явагдсан МЗСХ-ны хуваарьт албан ёсоор орсон тэмцээнүүдэд хувийн дүнгээр амжилттай оролцож, медальт болон шагналт байрт шалгарсан байх, чансааны дагуу жагсаалтын эхний 20-д орсон байх.  
Үүнд өмнөх загасчлалын улиралд үзүүлсэн амжилтуудыг авч үзэх бөгөөд шигшээ багийг эрт бүрдүүлэн бэлтгэл сургуулилалт хангах, төсөв зардал шийдвэрлэх, виз, бичиг баримт бүрдүүлэх гэх мэтийг шийдвэрлэх хангалттай хугацааг тооцно. (Үүнтэй уялдуулан УАШТ-үүдийг ДАШТ явагдсаны дараа тухайн улиралд багтаан хийхээр төлөвлөдөг байна)
  - 3.2.5. Тухайн төрлийн УАШТ-ний үр дүнгийн чансааг голчлон авч үзэх боловч, жигд амжилт гаргаж байгаа эсэхийг тодохойлохын тулд тухайн төрлийн бусад тэмцээнүүдийн чансааг харгалзан үзнэ
  - 3.2.6. Бусад тамирчдын дунд ёс зүй, шударга байдал, ур чадвараараа хүлээн зөвшөөрөгдөх (ёс зүйн ямар нэгэн асуудал, доголдол гаргаагүй байх)
  - 3.2.7. Тухайн төрлөөр ОУ-ын тэмцээнүүдэд оролцсон, эсвэл өмнө нь шигшээ багт багтаж ДАШТ-д оролцсон байж болно
  - 3.2.8. ДАШТ-д өөрийн хувийн зардлаар эсвэл зардлаа шийдвэрлэн оролцох боломжтой байх
  - 3.2.9. Бэлтгэл сургуулилалт, сургалт үйл ажиллагаанд тасралтгүй оролцох цаг хугацааны боломжтой байх (албан ажил, ар гэрийн асуудалгүй байх)
- 3.3. Шигшээ багт орох шаардлагуудыг хангасан тамирчдад чансааны эхнээс дараалан шигшээ багт орох саналыг тавих бөгөөд тухайн тамирчин орох боломжгүй тохиолдолд дараах эрэмбийн тамирчинд санал тавих зарчмаар явагдана. Шигшээ багийн бүрэлдэхүүн дэх тамирчны тоо нь загасчлалын

тухайн төрлийн ДАШТ-ний дүрмэнд заагдсан нэг улсын багийн тамирчны тооноос 2 дахин их байх хэмжээгээр хязгаарлагдана. (Дагалдан явах болон тамирчнаас бусад гишүүд энэ тоонд хамаарагдахгүй)

- 3.4. Өмнөх шигшээ багт багтсан тамирчдын хувьд чансааны жагсаалт болон шигшээ багийн шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд шигшээ багт хэвээр үлдээнэ.
- 3.5. Шигшээ багт орох шаардлага хангаж МЗСХ-оос санал хүргүүлсэн тамирчид нь анкет, хүсэлт болон бусад шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.
- 3.6. МЗСХ нь шигшээ багт багтсан тамирчин, дасгалжуулагч нэг бүртэй ёс зүй, үүрэг хариуцлагын гэрээ байгуулна.
- 3.7. Дараах төрлүүдээр шигшээ багийг бүрдүүлнэ. Үүнд:
  - 3.7.1. Мөсний загасчлалын шигшээ баг
  - 3.7.2. Спиннингийн загасчлалын шигшээ баг
  - 3.7.3. Флайн загасчлалын шигшээ баг, Флайн загасчлалын мастеруудын шигшээ баг, Флайн загасчлалын эмэгтэйчүүдийн шигшээ баг
- 3.8. Шигшээ багийн бүрэлдэхүүнийг МЗСХ-ны гишүүн холбоо, клубууд, тамирчид, олон нийтэд нээлттэй мэдээнэ.

### **Дөрөв. Шигшээ багийн үйл ажиллагаа**

- 4.1. Загасчлалын спортын тухайн төрлийн шигшээ баг нь тив, ДАШТ-д Монгол улсыг төлөөлж оролцоно.
- 4.2. Шигшээ багийн ерөнхий дасгалжуулагчийг МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын санал оруулснаар Удирдах зөвлөл хэлэлцэж, баталгаажуулна.
- 4.3. Шигшээ багийн тамирчдын бүрэлдэхүүнийг энэхүү журамд заагдсан шаардлагын дагуу шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч бүрдүүлэн, МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга баталгаажуулан, чиглэл удирдамжаар ханган ажиллана.
- 4.4. Шигшээ багийн бэлтгэл, сургуулилалт, сургалт, ёс зүй, өдөр тутмын үйл ажиллагааг шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч удирдан явуулна.
- 4.5. Шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 4.5.1. Биеийн тамир, спортын чиглэлээр их, дээд сургууль төгссөн эсвэл мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан бол давуу талтай
  - 4.5.2. Шигшээ багийг амжилт гаргахад хөтлөх чин эрмэлзэлтэй, эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд тогтвортой байх
  - 4.5.3. Хувийн ёс зүй, манлайлал, харилцааны соёлтой байх (ёс зүй, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй байх)
  - 4.5.4. Загасчлалын спортын төрлүүдээр ур чадвар, судалгаа, туршлагатай байх
  - 4.5.5. Тухайн дасгалжуулагчийн бэлтгэсэн тамирчдын гаргасан амжилт өсөлттэй байх
  - 4.5.6. Тухайн төрлийн ДАШТ-ний дүрмийн талаар гүнзгий мэдлэгтэй байх
  - 4.5.7. Гадаад хэлний зохих түвшний мэдлэг, ярианы чадвартай байх
- 4.6. Шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч нь шигшээ багийн тамирчдын дунд тив, ДАШТ-д оролцох сонгон шалгаруулах өрсөлдөөнийг явуулж, гарааны тамирчдыг сонгох, сэлгээний тамирчныг сонгох, тамирчдын сэтгэл зүй, бие бялдар, эрүүл мэндийн асуудлыг тогтмол хянаж шаардлагатай шийдвэрийг гаргах эрхтэй байна.
- 4.7. Шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч нь Монгол улсын нэр, эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, амжилт гаргах үүрэг хүлээх бөгөөд аливаа шийдвэрийнхээ хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 4.8. Шигшээ багийн харилцаа холбоо, бичиг хэрэг, зохион байгуулалттай холбоотойгоор шигшээ багийн ерөнхий дасгалжуулагчийн удирдлага дор шигшээ багийн менежерийг сонгон ажиллуулж болно.
- 4.9. Шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч нь тив, ДАШТ-нд оролцсон талаарх тайланг тэмцээнээс ирсэнээс хойш 14 хоногийн дотор гарган Ерөнхий нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөх үүрэгтэй. Тайланд тэмцээний зохион байгуулалт, дүн мэдээ, гаргасан амжилт, тамирчдын оролцоо, алдаа оноо, өөрийн дүгнэлт, ирээдүйн төлөвлөгөөг тусгана.

- 4.10. МЗСХ нь шигшээ багт гадаадын улс орнуудаас дасгалжуулагч урин ажиллуулах, гадаадын улс орнуудтай хамтарсан бэлтгэлд гаргах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болно.
- 4.11. МЗСХ нь тив, ДАШТ-д бэлтгэх, амжилттай оролцуулах зорилгоор тодорхой болзол, төсөв санхүү, хугацаатайгаар шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөн хийж болно.
- 4.12. Дараах тохиолдолд шигшээ багаас тамирчин, дасгалжуулагчийг хасна. Үүнд:
- 4.12.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлээгүй
  - 4.12.2. Ёс зүйн хувьд асуудал гарган, сахилгын арга хэмжээ авагдсан
  - 4.12.3. Гадаадын улс орон, дотоодын бэлтгэл цугларалт, тэмцээн уралдаанд оролцох үедээ Монгол улсын нэр хүндэд харшлах аливаа үйлдэл, эс үйлдэл гаргасан
  - 4.12.4. Допинг хэрэглэсэн нь тогтоогдсон
  - 4.12.5. Монгол улсын болон ОУ-ын хууль, тогтоомж зөрчин хэрэгт холбогдсон
  - 4.12.6. Өөрийн хүсэлтээр гарах (Энэ тухай хүсэлтээ бичгээр гаргана)
  - 4.12.7. Нас барах